



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 1/05

Онги

2023 оны цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/322 тоот тушаалаар батлагдсан цэргийн тоо бүртгэл зохион байгуулах журам, Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/552 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны цэргийн бүртгэл явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Болоржаргал (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Багийн Засаг дарга нар

Хэсгийн мөрдөгч

2. Сумын хугацаат цэргийн алба хаах насны болон цэргийн бүртгэл үүрэгтэй иргэдийн бүртгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 05-наас 01 дүгээр сарын 13-ны өдрүүдэд явуулахыг ажлын хэсгийн ахлагч (С.Болоржаргал) болон гишүүдэд үүрэг болгосугай.

3. Монгол Улсын дайчилгааны тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Цэргийн албаны тухай хуулиудад заагдсан “Улсын дайчилгааны төлөвлөгөө”, “Зэвсэгт хүчний анги байгууллагыг хүн хүч, техникээр хангах төлөвлөгөө”, “Сумын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ний дагуу сумын хуулийн этгээдүүдийн улсын дайчилгааны даалгавар (хүнс болон эд хэрэгслийн тооцоо) цэргийн дайчилгааны даалгавар, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн оногдуулан данслагдсан бэлтгэл үүрэгтэй иргэд, авто техник, өөрөө явагч хэрэгсэл, ангийн буу зэргийг нэг бүрчлэн бүртгэж тоолж даалгаваржуулахыг ажлын хэсгийн ахлагч (С.Болоржаргал)-д даалгасугай.

5. Бүртгэлийг зохион байгуулахтай холбогдуулан иргэд, цэргийн үүрэгтнүүдэд 2016 онд шинэчлэгдэн батлагдсан батлан хамгаалахын багц хууль, 2018 онд батлагдсан орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан цэргийн албыг биеэр хаах журам, мөн тус оны

Засгийн газрын 11 дүгээр тогтоолоор батлагдсан цэргийн гэрээт алба хаах журам зэрэг бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүдийн тухай цэргийн жинхэнэ алба хаах тухай хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хэрэгслээр сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг шуурхай зохион байгуулж цэргийн бүртгэлийн зөрчилтэй, завсардагчид болон урьд онуудын болон 2022 оны хоёр дугаар ээлжийн цэрэг татлагаас зайлс хийсэн хамрагдаагүй цэргийн үүрэгтнүүдийг эрэн сурвалжлах бүртгэлд хамрагдуулах ажлыг хэсгийн мөрдөгч (Ш.Ууганбаяр)-т, холбогдох албан тушаалтнуудтай хамтран ажиллаж тоо бүртгэлийн журам зөрчигчдийн нэрсийн жагсаалтыг гарган ямар арга хэмжээ авсан тухай мэдээг, мөн цэргийн бүртгэлийн мэдээ, тайлангуудыг 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 246 дугаар журмын дагуу нууцлан дэвтэрлэж аймгийн цэргийн штабт хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн ахлагч (С.Болоржаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  С.АМАРСАНАА

